

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭСТ ХҮРГҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЗАХИРАМЖИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2018.07.25

Чойр хот

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд гаргасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт 175 захирамжийг хяналтанд авч хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 116, хэрэгжих шатанд буюу 70 хувьтай 24, 30 хувьтай 27, хугацаа болоогүй 3, үнэлэх боломжгүй 5, ерөнхий дундаж үнэлгээгээр 84,4 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3 дугаар зүйлд заасны дагуу захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг тооцдог аргачлалыг баримтлаж үнэлсэн.

Хууль эрх зүйн хэлтээс ирүүлсэн аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүчингүй болсон 5 захирамжийг үнэлэх боломжгүй гэж тооцсон байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалд “**үнэлэх боломжгүй**” үнэлгээ байхгүй учраас гүйцэтгэлийн хувийг буруу тооцсон байна. Хүчингүй болсон захирамжийг хүснэгтээр танилцуулж байна.

№	Эрх зүйн актын нэр Огноо, дугаа	Зүйл заалтын дугаар, агуулга	Биелэлт	ХШҮ-ний дүн
01	Үнэлгээний хороо байгуулах тухай 2018.01.04 А/02	1.2018 оны аймгийн “Авто замын сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Дөрвөн замын уулзварт гэрлэн дохио суурилуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. 2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Д.Батцэцэг/-д үүрэг болгосугай.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр уг ажлыг гүйцэтгэх болсон тул аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дугаар А/183 захирамжаар хүчингүй болгосон. Үнэлэх боломжгүй	Захирамж гарснаас хойш 5 сарын хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус байгаа байна. Хэрэгжилт 0 хувь

02	<p>Үнэлгээний хороо байгуулах тухай 2018.01.04 А04</p>	<p>1 2018 оны аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Боржигины өргөн чөлөөний 5 дугаар гудамжийг жишиг болгон засварлах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. 2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Д.Батцэцэг/-д үүрэг болгосугай.</p>	<p>ОНХС-аар “Дөрвөн замын уулзварт гэрлэн дохио суурилуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороотой уг ажлын тендерийг хамтад нь үнэлэх Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дугаар А/183 захирамж гарсантай холбогдуулан хүчингүй болсон.</p>	<p>Шалтгаан тодорхой бус Хэрэгжилт 0 хувь</p>
03	<p>Орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай 2018.01.24 А/25</p>	<p>1. Үндэсний аюулгүй байдлын асуудлаар Засаг даргын даргын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Үндэсний аюулгүй байдлын ажлын албатай харилцах, мэдээлэл дамжуулах асуудлыг хариуцан зохион байгуулж, Үндэсний аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллах орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. 2. Орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг салбар зөвлөлийн дарга /Д.Содном/-д үүрэг болгосугай.</p>	<p>2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр ханган ажиллах орон тооны байнгын ажлын хэсэг байгуулах тухай Үндэсний аюулгүй байдлын газрын зөвлөж ирсэн тул аймгийн Засаг даргын А/191 дүгээр захирамжаар хүчингүй болгосон. Үнэлэх боломжгүй</p>	<p>Зохион байгуулалтын арга хэмжээг заавал бичих Хэрэгжилт 0 хувь</p>
04	<p>Соёл урлагийн хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2018.02.23 А/63</p>	<p>1. “Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай. 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 47 500 000 /Дөчин долоон сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжил сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Н.Одонтуяа/-д зөвшөөрсүгэй.</p>	<p>Аймгийн Засаг даргын 2018 оны А/110 дугаар захирамжаар уг захирамжийг хүчингүй болгосон. Үнэлэх боломжгүй</p>	<p>2018 оны А/110 дугаар захирамжаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Өмнөх захирамжинд ямар өөрчлөлт орсон нь тодорхой бус байна. Хэрэгжилт 0 хувь</p>
05	<p>Үнэлгээний хороо байгуулах 2018.03.12 А/73</p>	<p>1. Аймгийн 2018 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс аймгийн аюулгүйн нөөцөд өвс бэлтгэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний</p>	<p>Аймгийн аюулгүйн нөөцөд өвс бэлтгэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах</p>	

		хороог доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай 2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ш.Билэггүмбэрэл/-д даалгасугай.	ажлын хэсгийг аймгийн Тамгын газрын даргын тушаалаар батлах байсан тул уг ажлын хэсэг ажиллаагүй болно . Үнэлэх боломжгүй	Шийдвэр буруу гарсан Хэрэгжилт 0 хувь
Үнэлгээ ахиулсан захирамж				
1	Ажлын хэсэг байгуулах тухай 2018.03.28 А/111	1. 2018 оны аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Боржигин чуулгад шинэ уран бүтээлийн хувцас худалдан авах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. 2. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллах, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл тайланд тусгаж, эзэмшил ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-д үүрэг болгосугай.	Боржигин чуулгад шинэ уран бүтээлийн хувцас худалдан авах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг 6 аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэх тухай албан тоотыг бэлтгэн хүргүүлээд байна. Хэрэгжилт 30 хувь	Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулаад гэрээ байгуулж санхүүжилтэнд 13,7961,0 төгрөгийн олгосон байна Хэрэгжилт 100 хувь
	Ажлын хэсэг байгуулах тухай 2018.03.28 А/112	1. Театр чуулгуудын дунд зохион байгуулагдах улсын уралдаанд бэлтгэж оролцуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. 2. Уралдаанд бэлтгэлийг сайтар хангаж амжилттай оролцуулахыг комиссын дарга /С.Уранцэцэг/-т даалгасугай.	Театр чуулгуудын дунд зохион байгуулагддаг улсын уралдаанд бэлтгэж оролцуулах комисс хуралдаж ажлын төлөвлөгөө, төсвийг гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу тоглолтын хувцас худалдан авах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хэрэгжилт 30 хувь	Төлөвлөгөө гаргаж батлуулсан. Хувцас худалдаж авах бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Хэрэгжилт 100 хувь

Захирамжийн гол зорилт арга хэмжээгээ бүрэн хангасан 30 хувьтай 2 арга хэмжээг 100 хувь болгон өсгөж үнэллээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр нийт 175 захирамжийн үнэлгээ хувьд дараах байдлаар өөрчлөгдөж хэрэгжилтийг 82,7 хувийн биелэлттэй гарлаа.

		Өөрийн үнэлгээ	ХШҮ-ний үнэлгээ
Хяналтанд авсан нийт захирамжийн тоо		175	175
Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо		175	175
Хэрэгжилтийн үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн	100	118
	Хэрэгжих шатанд	70	24
	Хэрэгжилт хангалтгүй	30	25
	Хэрэгжээгүй	0	5
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй		3	3
Биелэлтийн хувь		84,40	82,7

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Захирамжийн хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн зорилтод зүйцүүлж, оновчтой, бүрэн гүйцэтгэд тайлагнах
2. Тайлагналт хангалтгүй ирүүлж байгаа тохиолдолд харьяалах хэлтсээс нь заавал тодруулж хэрэгжилтийг хангуулах тал дээрх анхаарч ажиллах
3. Захирамжийн хэрэгжилтийг хугацаанд тайлагнаж байх
4. Хэрэгжилт хангалтгүй 30 хувь болон хэрэгжээгүй 0 хувиар үнэлэгдсэн захирамжийн ард шалтгааныг заавал тодорхой бичих

ХШҮ хийсэн:

ХШҮДАХ-ийн мэргэжилтэн

П.Наранмандах

